

79



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 3/12

Номгон

**Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд
нэмэлт өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19.1, 18.1.2-ын "б", Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.11.1, 19.1.2, 19.1.3 дахь заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хөрөнгө санхүүг батлагдсан арга хэмжээнд зарцуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Э.ЭНХБАТ

1200044

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны
06 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны
3/12 дугаар тогтоолын хавсралт



АЙМГИЙН 2021 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

Д/д	Төслүүд	Нийт төсөв	Хийгдэх ажил	Хийгдэх хугацаа
1	Ковид-19 цар тахлын үед, нэн шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг нөөцлөх, тоног төхөөрөмжөөр хангах	500,000,000	Голомтод ажиллаж буй эрүүл мэндийн байгууллагын ажилтан албан хаагчдыг урамшуулах, нэн тэргүүнд шаардлагатай эм тариа, багаж хэрэгслээр хангах, нөөцлөх	07 сард
2	Ковид-19 цар тахлын хүрээнд Нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмж, автомашинаар хангах	270,000,000	Нэгдсэн эмнэлэг тоног төхөөрөмж -15.2 сая, Мэс заслын багаж тоног төхөөрөмж-9.9 сая, 31 орны мөнгө -15.0 сая төгрөг, Яаралтай тусламжинд нэн шаардлагатай түргэн шуурхай, найдвартай үйлчилгээ үзүүлэх land-200 маркийн автомашин-230.0 сая төгрөг	04-05 сард
3	Нэгдсэн эмнэлгийн тусгай зориулалтын хог хаягдлын төв	31,000,000	Халдварт цар тахал бий болсонтой холбогдуулж эмнэлгийн тусгай зориулалтын хог хаягдлыг стандартыг дагуу устгах зориулалт бүхий хог хаягдлын төв, тоног төхөөрөмжтэй болох	08 сард
4	Баянхонгор-тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазарт нэн шаардлагатай тоног төхөөрөмж, автомашинаар хангах	366,000,000	Аймгийн төвийн хатуу хучилттай автозамуудын өвөл зуны цэвэрлэгээ үйлчилгээг хийх автомашин-211.0, Зам талбайн усалгаа, ариутгалын автомашин-50.0, Нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд - 100.0 сая төгрөг	04-05 сард
5	Аймгийн төвийн болон гэр хорооллын гэрэлтүүлгийг шинэчлэх болон засварлах	410,000,000	Төв зам дагуу ОБГазраас амьчуулын аюулгүй тойрог хүртэлх замын 90 ширхэг гэрэлтүүлэг	06 сард
			Аймгийн төвд байгаа бүх барилга, орон сууцнуудыг туузан гэрэлээр хүрээлэх	06 сард
			7 дугаар багийн 2-28 дугаар гудамж хүртэлх, 2 дугаар багийн 1-36 дугаар гудамж хүртэл, 9 дүгээр багийн 1-17 дугаар гудамж хүртэл, 3 дугаар багийн 6-28 дугаар гудамж, 11-22 дугаар гудамж, Шинэ төгөл, Нисэхийн зам дагуу, ХҮДС-ийн зам дагуу, 10 мянгат буурал хайрхан дэлгүүрээс хойш	06 сард

6	Аймгийн төвийн Ногоон байгууламж болон аймаг төвийн Ойн зурвасын моджуулалтыг нэмэгдүүлэх, шаардлагатай газруудад нөхөн тарилт хийх	400,000,000	Аймгийн төвийн зам дагуух ногоон байгууламжийг нэг стандарт болгож зүлэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шинэчлэх	05 сард
7	Явган замын хавтангийн үйлдвэрлэлтэй болох Аймгийн төвийн А бүсийг тоосжилтоос хамгаалахад нэн шаардлагатай шороон хэсгүүдийг бетонон хучилт болон явган замын хавтангийн хучилт хийх	1,000,000,000	"Нэгдэлчин" зочид буудлын уулзвараас төв дөрвөн замын уулзвар хүртэлх 3300 м2 зам дагуух явган зам хийх	06 сард
			"Нэгдэлчин" зочид буудлын уулзвараас Мазаалай парк уулзвар хүртэлх бетон зам дагуух 2520 м2 явган зам хийх	06 сард
			АПУ бөөний төвөөс Арван мянгатын бетон замын уулзвар хүртэлх явган зам хийх	06 сард
			Аймгийн төвийн нийт явган замын засвар	07 сард
	Баянхонгор аймгийн төвийн А бүсийг тоосжилтоос хамгаалахад нэн шаардлагатай шороон хэсгүүдийг бетонон хучилт болон явган замын хавтангийн хучилт хийх			07 сард
8	"Чандмань-Баянхонгор" ХК-ний үйл ажиллагааг дэмжих, ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх	300,000,000	Ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цэвэр усны хяналтыг сайжруулах хяналтын лаборатортой болоход дэмжлэг үзүүлэх	08 сард
9	Баянхонгор сум, Өлзийт сум, Бууцагаан сумын байнгын хяналтын цэгийг түшиглэн улсын чанартай автозамд зорчиж байгаа тээврийн хэрэгслийн дундаж хурдыг тогтоох хяналтын камер авах	120,000,000	Хурд хэмжигчийг байрлуулснаар тус замаар зорчиж буй иргэдийн аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлнэ.	08 сард
10	Онцгой байдлын уулзварыг гэрлэн дохиотой болгож замын хөдөлгөөнийг зохицуулах	80,000,000	Гэрлэн дохиогоор зохицуулагдах уулзварын нэг бөгөөд хотын болон автозамын соёлд сургана.	07 сард
11	Хүүхэд залуучуудын спорт цогцолбор болон амралт зугаалгын бүсийн тохижилт	500,000,000	Оготнотой булгийг түшиглэн хүүхэд залуучуудад зориулсан спорт цогцолбор /сагсан бөмбөг, хөлбөмбөг, крикетийн талбай/, иргэдийн амрах, зугаалах, салхилах орчин нөхцлийг бүрдүүлсэн явган болон дугуйн замтай/	06-07 сард
12	Аймгийн онцгой байдлын газрын уулзвараас хүнс хөдөө аж ахуйн газрын уулзвар хүртэлх 0.75 км хатуу хучилттай автозамын ажлын төсөв	451,857,442	Аймгийн төвийн автозамын шаардлага хангахгүй эвдрэл ихтэй зам бөгөөд зайлшгүй шинээр хучилт хийх шаардлагатай.	07 сард

13	60*48 дугаар байрны дундах Хүүхдийн тоглоомын талбай болон автомашины зогсоол	212,500,000	Нийтийн орон сууцны байрнуудад түгээмэл тулгамдаж буй иргэдийн амарч салхилах болон хүүхдийн тоглох тоглоомын талбайг шат дараатай шийдвэрлэх, тус газарт тоглоомын талбай байгуулснаар ойролцоох 3-4 байрны 1000 гаран иргэний амрах, тоглох, салхилах таатай орчин бүрдэнэ.	06 сард
14	Баянхонгор аймгийн сум дундын ойн ангийн ажилчдын ажлын байр барих	32,000,000	Сум дундын ойн ангийн ажилчдын ажлын байрыг мод үржүүлгийн хашаанд нь барихаар шийдвэрлэсэн ба ингэснээр ажилчид ажлын байран дээрээ тогтвор суурьшилтай ажиллах боломж нөхцөл бүрдэнэ.	08 сард
15	"VR-Bayankhongor" төвийг байгуулж Аймгийн үзэсгэлэнт газаруудад виртуал аялал хийх боломжийг бүрдүүлэх	250,000,000	Аялал жуулчлалыг хөгжүүлэх, аймгийнхаа үзэсгэлэнт газруудыг сурталчлан таниулахад гол үүрэгтэй.	07 сард
16	Соёлын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	60,000,000		05 сард
17	Архивын тасгийн тавиур шүүгээ	59,500,000	Шинээр архивын барилга бий болсонтой холбоотойгоор архивын тасгийн тавиур шүүгээ зайлшгүй шаардлагатай	08 сард
18	Баянхонгор аймгийн 80 жилийн ойг угтаж 40 өрхийг өргөө цагаан гэртэй болгох	100,000,000	Аймгийн хэмжээнд 80 жилийн ойн хүрээнд 40 айл өрхийг өргөө цагаан гэртэй болгоно.	06 сард
19	Гэмт хэрэг, зөрчил, гамшгаас урьдчилан сэргийлэх болон нөхцөл байдлын мэдээ мэдээллийг иргэдэд цаг алдалгүй тухай бүрт нь хүргэж ажиллах мэдээллийн LED дэлгэц байршуулах	45,000,000	Иргэдэд тухай бүр мэдээллийг хүргэх LED дэлгэц байршуулна.	08 сард
20	Студи байгуулах /Эрх зүйн хөтөч/, Экологийн цагдааг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	30,000,000	Экологийн цагдаад тоног төхөөрөмж нийлүүлсэн-9.8 сая	10 сард
21	Цагдаагийн газрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх	45,000,000	Цагдаагийн газрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх	04 сард
Нийт төсөв		5,262,857,442		